

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР**

**Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. /Даалгавар бүр 2 оноотой/

**Үрт амьтан**

*/өгүүллэгийн хэсгээс/*

...Хоёул шалбалзан баглаатай ачаагаа задлан үзвэл, үнэхээр нэг адсаганы завсар сурны өөдөс шиг гурван бор юм үрчилзэн хөрвөж байлаа. Мань хоёр адсагатай нь урт хорхойдоо дөхүүлэн тавивал цаадах нь элэг гэдсээ нялга болсноо үл анзааран тэмүүлэн очиж мушгиран эвхэрчээ. Дандий хөлстэй духаа ханцуйгаараа шудран арчаад “Ваа, зайлуул...үрт амьтан гэдэг...” гэж уулга алдаад “Дэмбээ минь, чи л наадахаа аваад мордохоос... Нутгийн чулуу төөрүүлж болохгүй...Оорцог хайрханы амьтан байлгүй...Тэр аяараа лус ч байгаа юм бил үү! Үхтэл үр гэж энэ дээ... Ийм нүдэнд зэвүүн амьтнаас тийм хүч тэнхээ, зөөлөн сэтгэл гарна гэдэг...Хүнд ярихад үнэмшимгүй юм... Явж үз! Бидэнд хараал, хорлолоо цацах юм билүү, хэлэх ч юм биш” гэж адган өгүүлэв. Дэмбээгийн сэтгэлд нэгэн зуур “Юун ч сүржин юм. Энд нь орхичихно биз” гэж бодсоноо өөртөө дэм эрэх санаатай Гэпил рүү харвал цаадах нь тээр тэнд овойж товойгоод сууж байлаа.

*/С. Дашдооров/*

1. Эх могойны үр зулзагыг эхэд юу гэж нэрлэсэн бэ?  
А.Нүдэнд зэвүүн амьтан      В.Оорцог хайрханы амьтан      С.Тэр аяараа лус  
D.Урт хорхой                      Е.Гурван бор юм
2. Амьтдыг нутагт нь буцаан хүргэх гол шалтгаан юу байв?  
А.Гэпил могойноос их айдаг учраас  
В.Дэмбээгийн сэтгэлд нэгэнзуур өөр бодол орсон учраас  
С.Дандий уулгалан учирласны улмаас  
D. Могой гурван үрээ дагуулаад шууд л явах гэсэн учраас  
Е.Урт хорхой элэг гэдсээ нялга болсноо үл анзааран тэмүүлэн ирсэн учраас
3. Дургүйцсэн үнэлэмжбүхий өгүүлбэрийг олоорой.  
А....Явж үз!  
В.Үхтэл үр гэж энэ дээ  
С.Ийм нүдэнд зэвүүн амьтнаас тийм хүч тэнхээ, зөөлөн сэтгэл гарна гэдэг  
D.Энд нь орхичихно биз  
Е. Дэмбээ минь, чи л наадахаа аваад мордохоос...
4. “Гэпил рүү харвал цаадах нь тээр тэнд овойж товойгоод сууж байлаа”–дүрийн зан байдлын илэрхийлэлд тохирсон хэлцийг сонгоно уу.  
А.Айвал бүү хий, хийвэл бүү ай  
В.Айж явбал аминд өлзийтэй гэгчээр  
С.Аавын хүү алагтай цоогтой, арын мод урттай богинотой  
D.Аргатай хүн арсланг өргөж, эвтэй хүн буга барина  
Е.Айсан хүнд аргал хөдөлнө
5. Эхийн өнгө аясыг зөв тодорхойлсныг олоорой.  
А. Эх могой элэг гэдсээ нялга болсноо үл анзааран үрдээ тэмүүлэн ирж буйг голлон өгүүлж буй тул гуниглуун өнгө аястай  
В.Гэпил зугтаад хол очсоныг өгүүлж буй тул айдсын өнгө аястай  
С.Дэмбээгийн сэтгэлд нэгэн зуур “Юун ч сүржин юм. Энд нь орхичихно биз” гэсэн бодол төрсөн учраас дургүйцсэн өнгө аястай  
D.Ачаанд нь могойн зулзага тээгдэж ирсэн тул зэвүүцсэн өнгө аястай  
Е. Нутгийн чулуу төөрүүлж болохгүй... Үхтэл үр гэж энэ дээ... Явж үз! Бидэнд хараал, хорлолоо цацах юм билүү, хэлэх ч юм биш гэсэн учраас сэрэмжилсэн өнгө аястай

6. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг нь олоорой.  
А.Урт амьтны үйлийн шалтгааныг тайлбарласан, үйл явдлын өрнөлтэй тул тайлбарламж, хүүрнэмж хосолсон хэв маяг  
В.Жинчдэд тохиолдсон явдлыг дараалан гаргасан тул хүүрнэмж  
С.Урт хорхойг алж гэмтээж болохгүйн учир начрыг баталсан тул эргэцүүлэмж  
D.Жинчдэд тохиолдсон явдлыг нэг цагт зэрэгцүүлэн зурагласан тул тоочимж  
E. Урт хорхойг зулзагатай нь нутагтаа буцаах шалтгааныг олон талаар задлан тайлбарласан тул тайлбарламж
7. Эхийн гол санаанд тохирох хэлцийг олоорой.  
А. Эхийн санаа үрд, үрийн санаа ууланд  
B.Үхтэл үр харам  
C.Үргүй хүн үхэхийн цагт гутамшиг  
D. Зовсны эцэст жаргах  
E.Эхээ муухай гэж үр нь голдоггүй, эзнээ муухай гэж нохой нь голдоггүй
8. “Ийм нүдэнд зэвүүн амьтнаас тийм хүч тэнхээ, зөөлөн сэтгэл гарна гэдэг” гэсэн өгүүлбэрийн онцолсон хэсгийн утгад тохирохыг нь олоорой.  
A.эсрэгцүүлсэн  
B.лавшруулсан  
C.зэрэгцүүлсэн  
D.харьцуулсан  
E.ойролцоо болгосон
9. “Хоёул шалбалзан баглаатай ачаагаа задлан үзэв” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг солин найруулбал аль нь оновчтой байх вэ?  
A.түргэндүү  
B.бушуухан  
C.гялсхийн  
D.хамаг хурдаараа  
E.алга урвуулах төдийд
10. “Адсаганы завсар сурны өөдөс шиг гурван бор юм үрчилсэн хөрвөж байлаа” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг сонгоорой.  
A.адилтгал  
B.зүйрлэл  
C.ёгтлол  
D.тойруулал  
E.хэтрүүлэл
11. “Хүнд ярихад үнэмшимгүй юм”-өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.  
A.Угсарсан нийлмэл өгүүлбэр  
B.Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр  
C.Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр  
D.Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр  
E.Холимог нийлмэл өгүүлбэр
12. “Ээ золиг, чи л наадахаа аваад морд доо” гэсэн өгүүлбэрт тохирох загварыг олоорой.  
A.Мэдрэх өгүүлбэр+энгийн өгүүлбэр  
B. Зөвших өгүүлбэр+энгийн өгүүлбэр  
C.Илэрхийлэх өгүүлбэр+энгийн өгүүлбэр  
D.Хандах өгүүлбэр+энгийн өгүүлбэр  
E. Энгийн өгүүлбэр+энгийн өгүүлбэр
13. Цөм бус бүтэцтэй өгүүлбэрийг олоорой.  
A.Хоёул ачаагаа задлан үзнэ  
B.Цаадах нь сууж байна  
C.Дандий духаа арчина  
D.Мань хоёр урт хорхойдоо дөхүүлнэ  
E.Хараал, хорлолоо цацна
14. Эхийн өгүүлбэрүүдээс тонгоргон хувиргасныг олоорой.  
A.Цаадах нь тээр тэнд сууж байлаа  
B.Нутгийн чулуу төөрүүлж болохгүйшүү дээ  
C.Дандий духаа арчив  
D.Ийм нүдэнд зэвүүн амьтнаас тийм зөөлөн сэтгэл, хүч тэнхээ гарна гэдэг  
E.Үхтэл үр харам гэж энэ чинь шүү дээ

15. Эхийн өгүүлбэрүүдээс найруулгын доод зэрэгт хувиргасныг олоорой.  
 А.Оорцог уулын хайрхан байлгүй  
 В.Цаадах нь тээр тэнд овойж оцойгоод сууж байлаа  
 С.Тэр аяараа лус, савдаг ч байгаа юм бил үү  
 D.Дандий магнайгаа ханцуйгаараа арчив  
 E.Нутгийн чулууг хөдөлгөж болохгүй
16. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонгоно уу.  
 хөрвөж бай-, элэг гэдэс, нялга бол-,.....  
 А. нэг адсага  
 В. хүч тэнхээ  
 С.зэвүүн амьтан  
 D.уулын хайрхан  
 E. гурван юм
17. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай үгийг олоорой.  
 А.баглаатай ачаа  
 В.сурны өөдөс  
 С.тэмээний бурантаг  
 D.нутгийн чулуу  
 E.нэхий дээл
18. “Үнэхээр нэг **адсага**ны завсар сурны өөдөс шиг гурван бор юм үрчилзэн хөрвөж байлаа”гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.  
 А.Дэвсгэр болгон хэрэглэх үхэр малын хатаж хорчийсон арьс  
 В.Хонь ямааны элдсэн, түүхий арьс  
 С.Элдсэн нэхий арьсны баахан хуучирсны нь  
 D.Үхэр, адуу, тэмээний арьс  
 E.Хуучин даавууны өөдсөөр хийсэн уут
19. “Чи л **наадахаа** аваад мордохоос...” гэсэн өгүүлбэрийн онцолсон үг ямар юмыг төлөөлснийг олоорой.  
 А.ачааг  
 В.эх могойг  
 С.эх могойг зулзагын хамт  
 D.адсагыг  
 E.гурван бор юмыг
20. Төрөл биш утгатай үгийг олоорой.  
 А. үрчий  
 В.үрчгэр  
 С.үрчгэнэ  
 D.үрчил-  
 E.үрчилз-
21. Эхээс сонгосон үгсээс үгийн бүтцээр буруу задалсныг нь олоорой.  
 А.зад+л+0+0+н  
 В. эвх+р+0+0+чээ  
 С.ач+аа+0+г+аа  
 D.үрч+лз+0+0+н  
 E.хор+л+0+0/ыг/+оо
22. “Хүнд ярихад үнэмшимгүй юм”гэсэн нийлмэл өгүүлбэрийн гол өгүүлбэрийнх нь өгүүлэгдэхүүнийг олоорой  
 А. Дандий  
 В.Хүн  
 С.Дэмбээ  
 D.Гэпил  
 E.Үрт амьтан
23. Зөв бүлэглэсэн /угсруулах холбоо/ хэсгийг сонгоорой.  
 А.бор юм, зэвүүн амьтан, баглаатай ачаа  
 В.зэвүүн амьтан, хүч тэнхээ, үрт амьтан  
 С.элэг гэдэс, зөөлөн сэтгэл, урт хорхой  
 D.нутгийн чулуу, элэг гэдэс, баглаатай ачаа  
 E.сурны өөдөс, хүч тэнхээ, хөлстэй дух
24. “Нутгийн чулуу төөрүүлж болохгүй” гэсэн өгүүлбэр дэх харьяалахын тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?  
 А.Бүхэл хэсгийн утга  
 В.Орны утга  
 С.Эзэмшлийн утга  
 D. Юмны тоо хэмжээний утга  
 E.Цаг хугацааны утга
25. “Сондгой, тусгаар ургасан уул, толгой хяр, хад, цохио”гэсэн тайлбарт тохирохыг нь олоорой.  
 А. Хайрхан  
 В.Оорцог  
 С.Уулын шил  
 D.Алтайн нуруу  
 E. Аариг толгод


26. “Дэмбээ минь, чи л наадахаа аваад мордохоос...” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой.  
А. салган онцлох В. магадлан онцлох С. батлан онцлох  
D. зэрэгцүүлэн онцлох E. ялгах дуудах
27. “Ваа, зайлуул” гэсэн өгүүлбэрээр илрэх баймж утгыг зөв тодорхойлсныг олоорой.  
А. уулгалах, өрөвдөх В. жигших, зэвүүцэх С. хайрлах, өрөвдөх  
D. эргэлзсэн, ёрлосон E. мэдрэх, дургүйцсэн
28. “Урт хорхойдоо дөхүүлэн тавивал” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой бэ?  
А. -сээр В. -нгээ С. -хлээр D. -нгүүт E. -ж
29. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.  
А. чи, энд, өөртөө, бид, тэнд  
В. чи, бид, энэ, тэр, ийм, өөрөө  
С. чи, энд, өөртөө, бид, тэнд, гурван  
D. чи, бид, хоёул, тэр, ийм, өөрөө  
E. чи, бид, улаан, тэр, ийм, биш
30. Цэгийн оронд зөв бичгийн дүрмийн алдаагүй үгийг нөхөөрэй.  
Ах морио .....
- А. эмээллээ В. эмээллэлээ С. эмээлэлээ D. эмээлэллээ E. эмээлээ
31. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.  
А. Сэрүүн салхиүе үе үлээх боловч дулаан бөгөөд ербусын тайван, аятай ажээ  
В. Сумандэлтэй өндөр зээрд морь унасан Эрдэнэ эмээлдээрээ ялимгүй хэлтгий сууж ямар нэгэн гүн бодолд дарагдана  
С. Саяхан хүүхдүүд байсан, одоо ингээд л гэрлэх болж байдаг. Цаг ч мөн хурдан юм даа гээд Итгэлтөөрөө цайхий жуув  
D. Би тэр хүүхнийг зориуд чанга чанга ширтэж байв.  
E. Чибитгийн анад гомдоорой би ч чамд тэр нэгэн цагт хязгааргүй сэтгэлтэй байсан минь үнэн.
32. Монголын нууц товчоо зохиолд: Жамуха тэргүүтэн нар Чингис, Тоорил хан нартай байлдахад “Бидэнд тэнгэрийн хилэн болов” гээд бутран дутаасан нь ямар утга учиртай вэ?  
А. Тоорил ханы хоёр гурван шид бүтээгч нар тарни уншиж байлдах аргагүй болгосон тул  
В. Чингисийн цэргүүд маш их хүч зоригтой, илт давуу тул цөмийг хүйс тэмтэрч болзошгүй сүртэй байсан тул  
С. Байлдаж байсан газар тохиромжтой биш, цэргүүд сүрдэж, мохож байсан тул  
D. Буйраг хан, Худуга зад /хур оруулах, шуурга шууруулах/ барьтал мөн үүсгэсэн арга нь тэдэн дээр бууж балчигт гулгаж явах аргагүй болсон тул  
E. Тухай үед маш хүчтэй шуурга шуурч их хохирол амссан тул
33. Монголын нууц товчоо зохиолд Чингис хаан:  
“...Халих ус бороонд, хайрах хүйтэн жаварт  
Ханатай гэрий минь харгалзан байж  
Халуун амий минь хамгаалан манаж  
Хаан сууринд хүргэсэн ...” гэж хэнийг магтсан бэ?  
А. Зэв, Сүбээдэй, Зэлмэ, Хувилай дөрвийг  
В. Улс орныг удирдаж байгаа мянганы ноёдыг  
С. Өмөг түшиг болсон Өэлүн ижийгээ болон ухаант хатдаа  
D. Боорчи, Зэлмэ зэрэг өрлөгүүдийг  
E. Хэвтүүл нарыг

34. “-Ах аа, Миний энд хатиг гарсан юм. Хөндвөл их өвддөг. Энүүгээр цавчаарай. Хатиг битгий хөндөөрэй гэж гараараа зааж хэлсэн нь амьсгаагаа дарж, чимээ аниргүй байгаа олонд тов тод сонстон зүрхийг шөвгөөр чичих шиг болов” – ямар зохиолын дүрслэлт хэсэг вэ?  
 А. “Убаши хунтайжийн тууж” МСУЗ  
 В. “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэг /Д.Нам/  
 С. “Халуун амьсгал” тууж /Д.Г/  
 Д. “Хув Нагваралын тууж” МСУЗ  
 Е. “Нууцыг задруулсан захиа” өгүүллэг /Б.Р/

35. Б. Лхагвасүрэн “Үр могой” найраглалын хэсгүүдээс эх хүний төрсөн цаг хугацаа, муу ёр совинг илэрхийлснийг олоорой.  
 А. Нар бүлэгнэн мандахаас өмнө, гал дүлэгнэн асахаас өмнө...  
 В. Сул асгарах халуун цусны тунараанд, сүвэгч нь сохор тэвнэ шиг толгойгоо дүрнэ...  
 С. Газардахын аранга тойрно, ганцаардлын айдас тойрно...  
 Д. Цаашаа наашаа холхих хөлөнд цас ёолно, цалалзах жаврын үзүүрт хад улина...  
 Е. Зэгэл үдэш шөнөтэй залгах, зөнөсөн нохой хий боргох...

36. Жангарын туужид:  
 “Буян төгс ааваа хөвгүүнгүй хаяад  
 Буман өрх албатаа ноёнгүй хаяад  
 Арван наймтай ангир улаан хатнаа  
 Ганц бие хаяад  
 Буурал халзнаараа ирж  
 Эзэн богдыг дагасан...” нь хэн бэ?  
 А. Догшин хар Санал В. Хүнд гарт Савар С. Арслангийн Араг Улаан-хонгор  
 Д. Баян Хүнхээн Алтан Цээж Е. Орчлонгийн сайхан Миньяан

37. Монгол бичгийн эхийг уншаад зөв хөрвүүлснийг олоорой.  
 А. Хандгайн толгой тогоонд ордог  
 Хадраны толгой галд шаруулдаг  
 В. Хандгайн толгой тогоонд орогтун  
 Хадраны толгой галд шаруулагтун  
 С. Хандгайн толгой тоонд орохтун  
 Хадраны толгой галд шаргалтун  
 Д. Хандгайны толгой даваанд уруудан  
 Хадраны толгой галтай сөргөлдөн  
 Е. Хандхайн толгойг тогоонд уругтун  
 Хадраны толгойг галд шудрахтун



38. “дээл” гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэн хэсгийг олоорой.  
 А. B. C. D. E.

39. Тийн ялгалын нөхцөлийг буруу дагуулсан хэсгийг олоорой.  
 А. B. C. D. E.

40. Холбох эгшгийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой.  
 А. B. C. D. E.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**

**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлцийг утгатай нь зөв харгалзуулаарай.


- |  |                         |
|--|-------------------------|
| a. Харжхандаххүнгүй                    | 1. зөндньорхих          |
| b. Чихэнддуулдахгүй, нүдэндхарагдахгүй | 2. муухайхарах          |
| c. Хялавцалавхийх                      | 3. биеэсээхолтгох, далд |
| d. Гонжийнжооголионыбаас               | 4. өнчин өрөөсөн        |
| e. Заяаньмэдэг                         | 5. басаждоромжилсон     |

2.2. Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- |   |                        |
|---|------------------------|
| a. Хонин шар нүдтэй<br>Хомбогор хөөрхөн хоншоортой...     | 1. Бэлгэ дэмбэрлийн үг |
| b. Урт цагаан туургатай<br>Уран тагнай хаяавчтай...       | 2. Зүйр цэцэн үг       |
| c. Хөндий зоог туулж<br>Хүн бүхнийг хөхөлзүүлэн...        | 3. Ерөөл               |
| d. Идсэн шүүс нь рашаан болж<br>Ижил сүрэг нь түм хүрч... | 4. Магтаал             |
| e. Ил газар морио уя<br>Итгэсэн хүнд үгээ хэл             | 5. Цол                 |

2.3. Зурагт зааснаар нэртэй нь зөв харгалзуулаарай.

- a. баавар
- b. хяр
- c. бүүрэг
- d. дэвс
- e. дөрөөний сур



2.4. Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3	4
a	Ялгах эгшигтэйүг	хүргэ	торго	булан	эмнэ
b	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгчээсбүтсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэх үг	бусад+аас	сурагчид+д	хоног+т	тэнхим+д
c	Зөөлнийтэмдэг “и” болох үг	ярь+сан	шуугь+ж	тарь+даг	сахь+даг
d	Эгшигт гийгүүлэгч эгшиггүйбичигдэх үг	сур+г	тоно+г	ярих+ нь	хаш+н
e	Үгийндундорсон “б”-гямаргийгүүлэгчийндараабичихвэ?	л,м,н,в	н,л,м,г	б,в,р,л	м,н,г,в